

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ШААРДАГДАХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

2018.02.05

Д/д	Үйлчилгээний төрөл	Эрх зүйн үндэслэл	Бүрдүүлэх бичиг баримт	Хандах хэлтэс
1	Хэрэв та Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад орохыг хүсвэл	УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"	1. Биеийн байцаалт /Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт 1-ийн дагуу/; 2. Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; 3. Монгол Улсын иргэний үнэмлэх; 4. Ажил эрхэлдэг бол ажил байдлын тодорхойлолт; 5. Төрийн албаны тухай хуулийн 16.2.1-д заасан асуудлаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт; 6. 4х6-ийн хэмжээтэй 2 хувь зураг;	
2	Хэрэв та Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөхийг хүсвэл	Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоол "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай"	1. Төрийн албан хаагчийн биеийн байцаалт /Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт 1-ийн дагуу/; 2. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; 3. Тухайн ажлын байранд мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх гэсэн шалгуур тавигдсан тохиолдолд мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийг хуулбарлан, эх хувийн хамт; 4. Хөдөлмөрийн болон Нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан, эх хувийн хамт; 5. Тухайн ажлын байранд гадаад хэлний мэдлэгийн тусгай шаардлага тавигдсан тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгддөг гадаад хэлний түвшин тогтоох шалгалт өгсөн тухай баримт бичгийг хуулбарлан, эх хувийн хамт; 6. Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт; 7. "4 х 6"-гийн хэмжээний цээж зураг 2 хувь; 8. Шалгалтын үйлчилгээний зардал төлсөн баримт;	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Бадамгэрэл Өрөөний дугаар: 316 Утас:7032-3538
3	Хэрэв та Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон	Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоол "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын нэгдүгээр хавсралт	1.Биеийн байцаалт /Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт 1-ийн дагуу/; 2.Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; 3. Монгол Улсын иргэний үнэмлэх; <i>/нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/</i> 4. Ажил байдлын тодорхойлолт;	

	шалгаруулалтад орохыг хүсвэл		<p>5. 4 х 6-ийн зураг 2 хувь;</p> <p>6.Тухайн ажлын байранд ажилласан жил заасан тохиолдолд хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан, эх хувийн хамт;</p> <p>7.Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, өөрийн мэдлэг ур, чадвараа илэрхийлсэн өргөдөл; (cover letter)</p> <p>8.Байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулж ирсэн байх; /<i>тухайн байгууллагын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллахын тулд бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, материаллаг бааз, бодлого, үйлчилгээний хувьд хэрхэн хөгжүүлэх, үйл ажиллагааг нь хэрхэн үр дүн, өгөөжтэй байлгах гэх зэрэг</i>/</p>	
4	Хэрэв та Дипломат, албан паспорт мэдүүлэх, сунгах бол	Засгийн газрын 2013 оны 320 дугаар тогтоол Журам батлах тухай /“Монгол Улсын дипломат, албан паспорт, буцах үнэмлэх олгох, эзэмших, хадгалах журам”/ Гадаад харилцааны сайдын 2016 оны а/36 дугаар тушаал	<p align="center">Дипломат, албан паспорт мэдүүлэх, сунгах бол</p> <p>1. Дипломат, албан паспорт мэдүүлэх хуудас;</p> <p>2. Тухайн албан тушаалтанд дипломат эсхүл албан паспорт олгохыг хүссэн төрийн байгууллагын албан бичиг;</p> <p>3. Тухайн албан тушаалд томилсон шийдвэрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;</p> <p>4. Иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;</p> <p>5. Ажлын газрын үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар;</p> <p>6. Гадаад албан томилолтын шийдвэр;</p> <p>7. Төлбөр төлсөн баримт;</p>	<p>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Гадаад харилцаа, төсөл хөтөлбөр, үйлдвэрлэлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн О.Гансүх Өрөөний дугаар: 301</p> <p>Утас:7032-2293</p>
5	Хэрэв та Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах,	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /2001 он/ “Согтууруулах ундаа худалдах,	<p align="center">Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах бол</p> <p>Иргэн бол:</p> <p>1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;</p>	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анхбилэг

	сунгахыг хүсвэл	<p>түүгээр үйлчлэх цэгийн талаар авах арга хэмжээний тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 72 дугаар тогтоол</p>	<p>2. Иргэний үнэмлэхний хуулбар; 3. Дэлгүүр болон үйлчилгээний газрын гадна дотно зураг; 4. Тохирлын гэрчилгээний хуулбар; 5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралын дэргэдэх орон тооны бус ажлын хэсэг нь МХЕГ-аас гаргасан стандарт, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрлийн шаардлага хангасан эсэх талаар гаргасан дүгнэлт; 6. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн цэгийн орчим оршин амьдардаг 50-иас доошгүй иргэдийн дунд түүвэр аргаар санал асуулга явуулан, иргэдийн олонхи зөвшөөрсөн тохиолдолд хэлэлцүүлэг зохион байгуулж, дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, санал асуулгын дүнг уламжлах тогтоол; 7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;</p> <p>Хуулийн этгээд бол:</p> <p>1. Байгууллагын тамга тэмдэг бүхий албан бичиг; 2. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар; 3. Дэлгүүр болон үйлчилгээний газрын гадна дотно зураг; 4. Тохирлын гэрчилгээний хуулбар; 5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх орон тооны бус ажлын хэсэг нь МХЕГ-аас гаргасан стандарт, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрлийн шаардлага хангасан эсэх талаар гаргасан дүгнэлт; 6. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн цэгийн орчим оршин амьдардаг 50-иас доошгүй иргэдийн дунд түүвэр аргаар санал асуулга явуулан, иргэдийн олонхи зөвшөөрсөн тохиолдолд хэлэлцүүлэг зохион байгуулж, дүнг сумын ИТХТэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, санал асуулгын дүнг уламжлах тогтоол; 7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;</p> <p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл сунгах бол</p> <p>1. Оршин байгаа газрын багийн Засаг даргын тодорхойлолт; 2. Оршин байгаа газрын Цагдаагийн байгууллагаас</p>	<p>Өрөөний дугаар: 212 Утас:7032-3087</p>
--	-----------------	--	---	--

			захиргааны зөрчлийн талаарх тодорхойлолт; 3. Хугацаа дууссан Тусгай зөвшөөрлийг эх хувиар хавсаргасан байх;	
6	Хэрэв та Эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авах, сунгахыг хүсвэл		1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/; 2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ; 3.Тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар; 4. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Р.Наранцэцэг Өрөөний дугаар: 201 Утас:7032-3086
7	Хэрэв та Эмчилгээний гоо заслын үйлчилгээ		1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/; 2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ; 3.Тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний нэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар; 4. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт; 5. Тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;	
8	Хэрэв та Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл авах, сунгахыг хүсвэл	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /2001 он/ Боловсролын тухай хууль /2002 он/	Дараах баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө бүрдүүлж ирүүлнэ. 1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/; 2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ; 3.Тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн	Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Долгорсүрэн Өрөөний дугаар: 201 Утас:7032-3086

			<p>хуулбар;</p> <p>4. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;</p> <p>5. Боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, өргөдөл, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг;</p> <p>6. Боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга;</p> <p>7. Сургалтын төлөвлөгөө;</p> <p>8. Багшлах боловсон хүчний хангамж, бүрэлдэхүүн, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа;</p> <p>9. Сургалт явуулах барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа;</p> <p>10. Санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа;</p> <p>11. Үүсгэн байгуулагчаас сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа;</p> <p>12. Байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл;</p> <p style="text-align: center;">Сунгах бол:</p> <p>Хугацаа сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас гурван сарын өмнө гаргана.</p>	
9	Хэрэв та Аймгийн архивын баримтаас лавлагаа мэдээлэл авахыг хүсвэл	Архивын ерөнхий газрын даргын 2015 оны а/168 дугаар тушаал “Төрийн архивын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай”	<p>1. Өргөдлийг маягтын дагуу бөглөсөн өргөдөл</p> <p>2. Иргэний үнэмлэх</p> <p>3. Гэрлэлтийн баталгаа</p> <p>4. Цэргийн үүрэгтний үнэмлэх</p> <p>5. Нийгмийн даатгал болон хөдөлмөрийн дэвтэр</p> <p>6. Үйлчилгээний хураамж төлсөн баримт</p>	Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг Утас:7032-2261

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР